



**Оюу толгойн уурхайн 2017 оны Байгаль орчны
менежментийн төлөвлөгөөний хураангуй**

Улаанбаатар

2017он

ГАРЧИГ

1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ	2
1.1. Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө ...	2
1.2. Ургамлын аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө ...	3
1.3. Усны нөөц хомсдол, усны чанарын асуудал	4
1.4. Газрын менежментийн төлөвлөгөө.....	5
1.4.1. Газар хөндөлтийг хянах	5
1.4.2. Шимт хөрсийг хамгаалах.....	7
1.5. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	8
2. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	10
2.1. Биологийн олон янз байдал.....	10
2.2. Байгаль хамгааллын нэмэлт арга хэмжээ.....	10
3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	11
3.1. Техникийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	11
3.2. Биологийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	11
3.2.1. Ногоон байгууламж байгуулах.....	12
4. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	12
5. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	12
6. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	13
7. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	13
8. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ.....	14
9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	14
9.1. Усны түвшний болон чанарын хяналт шинжилгээ.....	14
9.2. Агаарын чанарын хяналт шинжилгээ.....	16
9.3. Хөрсний хяналт шинжилгээ	21
9.4. Ургамлын судалгаа	22
9.5. Амьтны аймгийн хяналт шинжилгээ.....	23

1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

1.1. Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 1. Амьтны аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ
1	Монгол улсын улаан ном, бүс нутгийн болон олон улсын улаан данс (IUCN), бусад хууль тогтоомж, гэрээ конвенциор хамгаалагдсан ховор, нэн ховор зэрлэг амьтдын талаар сургалт зохион байгуулах	ОТ компанийн үндсэн болон гэрээт компанийн ажилчдад
2	Шувууд цахилгаанд цохиулах эрсдэлтэй цахилгааны шонгууд дээр богино холболтын тусгаарлагч суурилуулах.	Гүний хоолой дахь 6.3 КВ-ын цахилгааны шугам, дэд станцууд
3	Сансрын дамжуулагч хүзүүвчтэй Хулангийн мэдээнд үндэслэн зам хөндлөн гардаг хугацаа, байршлыг нарийн тодорхойлж, шаардлагатай тохиолдолд тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах.	Оюу Толгой-Гашуун сухайт чиглэлийн хатуу хучилттай зам
4	Хууль бусаар амьтан агнах, ургамал түүх, тэдгээрийн гаралтай түүхий эдийг тээвэрлэх, ашиглахыг хориглох тухай журмыг хэрэгжүүлж, нэвтрэх хаалгууд, онгоцны буудал дээр хяналт шалтгалт явуулах	ОТ компанийн үндсэн болон гэрээт компанийн ажилчид, зочид
5	Зэрлэг амьтдын үргэн дайжих, шууд үхэл хорогдох эрсдлээс сэргийлэн төслийн холбогдолтой тээврийн хэрэгслүүдийг батлагдсан замаар зорчих, хурдны хязгаарыг баримтлах талаар ажилчдад сургалт явуулах, хянах	ОТ Гашуун сухайтын зам дагууд ОТ компанийн үндсэн болон гэрээт компанийн ажилчдад
6	Газар хөндөх зөвшөөрөл олгохын өмнө судалгаа хийж ховор амьтад, амьдрах орчныг хамгаалах талаар дүгнэлт гаргах, шаардлагатай бол зөвшөөрөл олгохоос татгалзах	Төслийн үйл ажиллагааны талбайн хэмжээнд
7	Хоолны үлдэгдлийн хаях, булшлах үйл ажиллагаанд хяналт тавих, ил задгай хаяхаас сэргийлж, элдэв идэшт шувуудын тоо толгойг үнэлэх	Төслийн талбай дахь хог хаягдлын менежментийн төв
8	Төслийн талбайд зэрлэг амьтдын тээврийн хэрэгсэлд дайруулах магадлалтай газруудыг тодорхойлох, шаардлагатай газар хурдны хязгаарыг багасгах, ажилчдад анхааруулах мэдээлэл бэлдэж хүргэх	Лицензийн талбайд
9	Оюу Толгой-Гашуун сухайт чиглэлийн хатуу хучилттай зам ашиглалтын эрчмийг үнэлж, ховор хөхтөн амьдын шилжилт хөдөлгөөнд саад учруулж буй эсэхийг хянах	Оюу Толгой-Гашуун сухайтын зам
10	Баяжуулах үйлдвэрээс ХХАБ-руу нийлүүлж, тунгааж буй усны чанарын хяналтыг Газрын доорх усны ОХШХ-т тусгагдсаны дагуу тогтмол хийх	ХХАБ-ын усны гадаргуу дээр бууж буй шувууд
11	Төслийн үйл ажилгааны талбай, дэд бүтцийн шугам дагуух үхсэн амьтны сэг зэмийг зайлуулах, булж устгах	Уурхайн талбай, дэд бүтцийн шугам дагуу

1.2. Ургамлын аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 2. Ургамлын аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ
1	Урт болон богино хугацаанд ашиглах газрын төлөвлөлтийн тухай мэдээллийг 3 болон түүнээс дээш сараар урьдчилан авч, тухайн талбайн суурь судалгааг талбай тус бүрд хийж ховор, нэн ховор ургамалд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээг шатлалын дагуу тодорхойлон, дүгнэлт-зөвлөмж гаргах	Төслийн үйл ажиллагааны талбайн хэмжээнд
2	ГХЗ хүссэн талбай тус бүрд хөрс, ургамлан бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг тодорхойлохын тулд суурь судалгааг: 1) чухал амьдрах орчны нэг хэсэг болох хайлас, тоорой бүхий сайрын ургамалжилттай талбай, 2) заган ой бүхий талбай, 3) бэлчээрийн нөөц талбай тус бүрээр ангилан хийж, нөлөөллийг бууруулах шатлалын дагууд авах арга хэмжээний зөвлөмж, дүгнэлтийг гаргах	Төслийн үйл ажиллагааны талбайн хэмжээнд
3	Хөндөгдөж буй талбайн ургамлын бүртгэл хөтлөх, тайлагнах	Төслийн үйл ажиллагааны талбайн хэмжээнд
4	Хөндөхөөс зайлсхийх шаардлагатай ургамлын зүйлүүдэд үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлохын тулд ажиглалт судалгаа хийх, мэдээлэл цуглуулах, удмын санг хадгалах арга технологийг судлах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах	Төслийн үйл ажиллагааны талбайн хэмжээнд
5	Уурхайн лицензийн талбай дахь ховор ургамлын тархалтын зураглалыг шинэчлэн гаргаж, газар ашиглагч нарт танилцуулах	Төслийн үйл ажиллагааны талбайн хэмжээнд
6	Хууль бусаар байгалийн ургамал түүх, тэдгээрийн гаралтай түүхий эдийг түүх, тээвэрлэх, ашиглахыг хориглох тухай журмыг хэрэгжүүлж, уурхайн талбайд хяналт шалтгалт явуулах	ОТ компанийн үндсэн ажилчид болон гэрээт компанийн ажилчид, зочид
7	Хууль бусаар байгалийн ургамал түүсэн тохиолдолд байгаль орчны зөрчлөөр бүртгэн, шаардлагатай арга хэмжээг авах	ОТ компанийн үндсэн ажилчид болон гэрээт компанийн ажилчид, зочид
8	Үйл ажиллагаа явуулж дууссаны дараа зэрлэг амьтдын амьдрах орчин болгон ашиглахаар төлөвлөж буй газрын нөхөн сэргээлтийг тогтоосон шалгуур үзүүлэлтүүдэд нийцүүлэн олон төрөл, зүйлээс бүрдсэн ургамлын бүлгэмдэл цаашид биеэ даан ургах чадвартай байхаар төлөвлөх	Төслийн үйл ажиллагааны талбайн хэмжээнд

1.3. Усны нөөц хомсдол, усны чанарын асуудал

Хүснэгт 3. Усны нөөцөд учруулж болзошгүй сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ
1	12 цооногийг сонгон авч, хааж битүүмжлэх ажлыг Өмнөговь аймгийн Ханбогд сум, гурван талт зөвлөлтэй хамтрах эхлүүлэхээр төлөвлөж байна.	GHW5x2, GHW6x2, GHW14x2, GHW15x1, GHW15x2, GHW15x4, GHEB05, GHEB04, GHTRM01, GHTRM03, GHEB07, GHEB06
2	Төслийн нийт усны хэрэгцээг багасгах, эргүүлэн ашиглах усны хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ авах, нэмэлт боломжуудын судлах, усны зохистой ашиглалтын талаар сургалт явуулах	ОТ компанийн үндсэн ажилчид болон гэрээт компанийн ажилчид, зочид
3	ХХБ, Хүчил үүсгэгч чулуулаг, БУЦБ, ил уурхайн шүүрлийн ус, ус зайлуулах систем зэрэг асуудлыг агуулсан усны менежментийн төлөвлөгөөг боловсруулсан ба түүний хэрэгжилтийг хангаж ажиллана	Төслийн үйл ажиллагааны хүрээнд
4	Ил уурхай шүүрч буй усыг тогтмол шавхах ба тусгайлан засч бэлтгэсэн зумфэд хуримтлуулан хадгалах, цэвэрлэгдэж хуримтлагдсан усыг хаягдал чулуулгийн овоолго болон нэвтрэлт орчмын тоосжилтыг багасгах зорилгоор ашиглана	Ил уурхайн үйл ажиллагааны хүрээнд
5	Үйлдвэрийн болон ахуйн бохир ус дамжуулах шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн ашиглалтад байнга хяналт тавьж, гэмтсэн тохиолдолд даруй засах арга хэмжээ авч байна	ОТ компанийн үндсэн ажилчид болон гэрээт компанийн ажилчид
6	Хаягдал шингэн болон цэвэрлэх байгууламжийн лагийг зөвшөөрөгдсөн цэгт зайлуулж байх	Тухай бүрд
7	ХХБ-д их хэмжээний талбайг хамарсан усан толио үүсгэхгүй байхад анхаарч ажиллах.	ХХБ, Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа
8	Гадаргын болон хөрсний усны урсгалыг хэвээр хадгалахын тулд өөрчлөгдсөн голдиролын урсгал үндсэн голдиролдоо эргэн нийлж буй эсэхэд тогтмол хяналт тавьдаг Нөхөн сэргээсэн хиймэл Бор овоогийн булгийн усанд мониторинг хийх	ОТ компанийн үндсэн ажилчид ЭМААБООН хэлтэс
9	БУЦБ-ын ойролцоох газрын гүний усанд хяналт шинжилгээ хийнэ	ОТ компанийн үндсэн ажилчид БО хэлтэс
10	Гүний хоолойн уст давхаргын усны түвшин бууралтыг зөвлөмжийн үзүүлэлтийн зохих хэмжээнээс илүү гарахаас урьдчилан сэргийлж, Гүний хоолойн уст давхаргын химийн найрлагад хяналт тавина	Гүний хоолойн ашиглалтын худгууд
11	БУЦБ-д орж буй болон цэвэрлэгдээд гарч буй бохир усанд байнгын хяналт шинжилгээ хийж байна	БУЦ байгууламж, БО хэлтэс
12	ХХБ-аас сар бүр усны дээжийн шинжилгээг иж бүрнээр хийлгэн, өөрчлөлт ажиглагдвал шалтгааныг тодорхойлох.	ЭМААБО хэлтэс
13	Химийн бодис ундны усны эх үүсвэрт алдагдахаас сэргийлнэ, ундны усыг тогтмол хугацаанд шинжлүүлж байна. Химийн бодисыг тээвэрлэх үеийн савны битүүмжлэл, бүрэн бүтэн байдлыг байнга шалгана, одоо ашиглаж байгаа агуулахууддаа стандартын дагуу ашиглахад байнгын хяналт тавина, асгарсан химийн бодисыг зориулалтын материалаар цэвэрлэж байна	ОТ компанийн үндсэн ажилчид болон гэрээт компанийн ажилчид, зочид
14	Шатах тослох материалыг алдагдахаас бүрэн сэргийлнэ, алдагдаж, гоожсон тохиолдолд зориулалтын материалаар цэвэрлэж байна	Төслийн үйл ажиллагааны хүрээнд

1.4. Газрын менежментийн төлөвлөгөө

1.4.1. Газар хөндөлтийг хянах

Хүснэгт 4. Газар, хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ
	2017 онд Газар хөндөх зөвшөөрлийн шинэчилсэн журмыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ	Төслийн хүрээнд
1	Газрын гадарга, хэвлий эвдэгдэх - Аливаа газар хөндөх үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө Газар хөндөх зөвшөөрлийн (дотоод) журмыг хэрэгжүүлэх	MV-006709 дугаартайтусгай зөвшөөрлийн талбай
2	Газрын гадарга, хэвлий эвдэгдэх - Газрын эвдрэлийг аль болох бага хэмжээнд байлгах талаар анхаарч, үйл ажиллагааг нарийн төлөвлөх, барилга байгууламжид ашиглагдаж буй талбайн хэмжээг чухал шаардлагагүй тохиолдолд нэмэгдүүлэхгүй байх, нөхөн сэргээх арга хэмжээ авах	Төслийн талбайн хэмжээнд; Байнга
3	Газрын гадарга, хэвлий эвдэгдэх - Уурхайн ухмалуудын хана, гадаргууг урт хугацааны турш тогтвортой байхуйцаар засч хэлбэржүүлэх, тогтворжилт муутай болон аюултай байдалд хүргэж болзошгүй ухмалууд, хаягдлын байгууламжуудыг уурхайн үйл ажиллагааны явцад болон уурхайг хаасны дараа засч тохижуулан, аюулгүй байдалд оруулах	Ил уурхай, Хаягдал чулуулгын овоолго, Баяжуулах үйлдвэрийн Хаягдлын сан, Дугатын хайрганы карьер
4	Газрын гадарга, хэвлийг бохирдуулах - Баяжуулах үйлдвэрийн цогцолбор, тэсрэх бодисын үйлдвэр, тэсрэх бодисын үйлдвэр, түлшний агуулах, ШТС, БУЦБ-ын тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг байнга шалгаж, гэмтэл илэрвэл шуурхай арга хэмжээ авах	Баяжуулах үйлдвэрийн цогцолбор, тэсрэх бодисын үйлдвэр, БУЦБ, ШТМ-ын агуулах, ШТС
5	Хаягдал хадгалах байгууламжын далангийн тогтворжилтыг байнга шалгаж байх, сэтрэх, задрах, халих эрсдэлээс хамгаалах	Хаягдал хадгалах байгууламж
6	Газар хөндөх үйл ажиллагааг хууль ёсны дагуу тогтоосон талбайд хязгаарлах	Уурхайн тусгай зөвшөөрөлтэй талбай
7	Шинээр газар хөндөхийг хязгаарлах төдийгүй, хүний эрүүл мэнд, байгаль орчин, биологийн олон янз байдал, экосистемийн үйлчилгээнд нөлөөлөл үзүүлэхээс аль болох зайлсхийх эсвэл нөлөөллийг бууруулах байдлаар барилга байгууламжуудын байршил, зураг төслийг төлөвлөх	Уурхайн тусгай зөвшөөрөлтэй талбайд хөндөгдөх талбай
8	Газрын эвдрэлийг аль болох бага хэмжээнд байлгах талаар анхаарч, зөвшөөрөгдсөн замаар тээвэрлэлт хийх.	Уурхайн тусгай зөвшөөрөлтэй талбай, түүний орчим
9	Барилга байгууламжид ашиглагдаж буй талбайн хэмжээг чухал шаардлагагүй тохиолдолд нэмэгдүүлэхгүй байх, тухайн цаг үед болон цаашид ашиглах шаардлагагүй болсон газарт нөхөн сэргээлтийг хийх	Уурхайн тусгай зөвшөөрөлтэй талбайд, бусад дэд бүтцийн шугамын дагууд
10	Ил уурхай болон гүний уурхайн үйл ажиллагаагаар хуримтлагдах нөлөөлөл үүсэх - Нөлөөллийг бууруулах шатлалын дагуу зайлсхийх, бууруулах, нөхөн сэргээхийн хамт дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг нөлөөлөл үргэлжлэх хугацаанд тогтмол, үр дүнтэй хэрэгжүүлэх	Хөндөгдөж буй талбайгаас хуулсан болон хуулагдсан өнгөн хөрсний овоолгууд
11	Хуулагдсан өнгөн хөрс салхи, усны нөлөөгөөр элэгдэж болзошгүй - Газар хөндөх үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө өнгөн хөрсийг хуулан авч, тусгайлан овоолго байгуулан, оновчтой байршуулан хадгалах арга хэмжээг үргэлжлүүлэн авах	Хөндөгдөж буй талбайгаас хуулсан болон хуулагдсан өнгөн хөрсний овоолгууд
12	Хуулагдсан өнгөн хөрс салхи, усны нөлөөгөөр элэгдэж болзошгүй - Өнгөн хөрсний овоолгыг салхины элэгдлээс хамгаалах буюу гадаргууг ургамалжуулах туршилтыг үргэлжлүүлэх, тухайн газраас хуулсан шимт хөрсийг тухайн газрын нөхөн сэргээлтэд ашиглахыг чухалчлах	Хоёр жилээс дээш хугацаагаар хадгалж байгаа болон хадгалах шимт хөрсний овоолгын дээд гадаргуу, хажуу

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ
13	Хуулагдсан өнгөн хөрс салхи, усны нөлөөгөөр элэгдэж болзошгүй - Хоёр жилээс дээш хугацаагаар хадгалах шимт хөрсний овоолгуудад чанарын хяналт шинжилгээ хийх, хадгалалт, хамгаалалт, тордолтын бүртгэл хөтлөх, хаягжуулах	Хоёр жилээс дээш хугацаагаар хадгалж байгаа болон хадгалах шимт хөрсний овоолгууд
14	Хатуу, шингэн хог хаягдал болон цэвэрлэх байгууламжын стандартын шаардлага хангаагүй бохир ус байгальд хаяснаар: химийн бодисын тээвэрлэлт, хадгалалт, ашиглалтын үед, хүнд машин механизмаас шатах тослох материал асгарах, төв дулааны станцын үнсэн сан, баяжуулах үйлдвэрээс Хаягдал хадгалах байгууламж руу нийлүүлж буй хаягдал ус хөрс рүү нэвчих, халих зэргээс хөрс бохирдож болзошгүй - Хог хаягдлыг зөвшөөрөгдсөн төвлөрсөн цэгт ангилан хаях	Төслийн талбайд
15	Химийн бодисыг тээвэрлэх үеийн савны битүүмжлэл, бүрэн бүтэн байдлыг байнга шалгах, одоо ашиглаж байгаа агуулахуудад стандартын дагуу ашиглахад байнгын хяналт тавих, асгарсан химийн бодисыг зориулалтын материалаар цэвэрлэх, шаардлагатай зохих газарт байршуулах	Химийн бодисыг тээвэрлэж буй машин техник, химийн бодисын агуулах, баяжуулах үйлдвэр, тэсрэх бодисын үйлдвэр
16	Баяжуулах үйлдвэр, тэсрэх бодисын болон бетон зуурмагийн үйлдвэр, БУЦБ-ын тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг байнга шалгаж, гэмтэл илэрвэл шуурхай арга хэмжээ авах	Баяжуулах үйлдвэр, тэсрэх бодисын болон бетон зуурмагийн үйлдвэр, БУЦБ
17	Хаягдал хадгалах боловсруулах төвийн шингэн хаягдлыг ууршуулах сангаас бохир ус хальж асгаран хөрс бохирдуулахаас сэргийлж төвшинд нь байнгын хэмжилт хийж, хянах	Хаягдал хадгалах байгууламж орчмын хөрсөн бүрхэвч
18	Төв дулааны станцын үнс, хог хаягдлыг тээвэрлэх, зөвшөөрөгдсөн газарт хаяхдаа Хог хаягдал боловсруулах журмыг баримтлах, тогтсон замаар тээвэрлэлт явуулах	Хог хаягдал боловсруулах төв, тээвэрлэлийн зам
19	Шатах, тослох материал алдагдахаас сэргийлж, асгаралт бий болж болзошгүй газруудад хамгаалалтын бетонон зэрэг суурь хийх	Шатахуун түгээх станц, хоолойнууд, агуулах
20	Аливаа асгаралтын үед хэрэглэх зориулалтын шингээгч материалыг зохих газруудад байршуулах	Шатахуун түгээх станц, хоолойнууд, агуулах
21	Гүний Хоолойн ус татах шугамын дагууд хөрсний элэгдэл, эвдрэлийг бууруулах - Газрын гадаргын хөрсний чийгийн ойр түүний өөрчлөлтийн хяналт шинжилгээний хөтөлбөрийг хөгжүүлэх ба бүсийн уст давхаргын усны төвшний бууралтаас үүсэх нөлөөллийг таних үзүүлэлтийг тодорхойлох	Гүний Хоолойн ус татах шугамын дагууд
22	Гүний Хоолойн ус татах шугамын дагууд хөрсний элэгдэл, эвдрэлийг бууруулах - Олон салаа зам гаргахгүй байх. Барилга байгууламжийн ажлаас шалтгаан эвдэрсэн газрыг нөхөн сэргээх	Гүний Хоолойн ус татах шугамын дагууд -
23	Бүх ажилчидад үйлдвэрийн болон ахуйн хэрэглээний аюултай материалтай харьцах асуудлаар цогц сургалт, зааварчилгаа явуулах, болзошгүй асгаралтын үед хариу арга хэмжээ авах хэрэгслүүдийг ажлын байруудад хангалттай хэмжээгээр байрлуулах	Бүх ажилчид
24	Цагаан хад - Гашуун сухайтын зам барилгын үед гарах аливаа хог хаягдлыг хаях зориулалтын хогийн цэг байгуулах, төвлөрсөн хог хаягдлыг зохих журмын дагуу тогтсон хугацанд сумын төвлөрсөн хогийн цэг рүү ачиж шилжүүлэх	ЦХ – ГС-ын замын барилгын талбай, түүнийг хэрэгжүүлэх хугацаанд
25	Зориулалтын засварын газар, талбайгаас өөр газарт тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аливаа засварын ажлыг хийхгүй байх, зориулалтын газар, талбайг (~40м ²) засаж тохижуулах, шаардлагатай элс зэрэг материалыг бэлтгэх	ЦХ – ГС-ын зам болон ХБ-ОТ замын барилгын талбай, түүнийг хэрэгжүүлэх хугацаанд
26	Зам барилгын ажлын бэлтгэл хангах үед хийгдэх хөрс цэвэрлэгээ, тэгшлэлт болон материалын ордуудыг нээх, суваг шуудуу, нүх цооног ухах зэрэг газар шорооны их бага бүх ажлын үед үржил шимт хөрсийг нимгэн зузаанаас хамааруулан хуулж, нөхөн сэргээлтэд буцаан ашиглах зориулалтаар түр овоолж хадгалах зам барилгын ажилд ашигласан карьер, ажлын талбарт нөхөн сэргээлт хийх (тайланд тусгасны дагуу), тогтоосон	Ханбогд-Оюу Толгой-Жавхлант баг чиглэлийн хатуу хучилттай авто замын барилгын ажлын талбай

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ
	газруудаас бусад газраас дүүргэлтийн материал авахыг хатуу талбар, карьер хооронд үүссэн түр замын хөрсийг сийрүүлэн биологийн нөхөн сэргээлт хийх	
27	Тээврийн хэрэгслийг маршрутын бус замаар явахыг хориглосон таних тэмдэг бүхий самбарууд, хөрс, ургамал зэргийг хамгаалах сурталчилгааны самбарууд байгуулах. Трассын дагуух барилгын ажлын хүрээнд газраад, дотоод замын зорчих хэсгийн өргөнийг тогтоож, хязгаарлалт хийх, тэмдэгшүүлэх арга хэмжээ авах. Мөн түүнчлэн зам барилгын ажлын хүрээнд хуучин шороон замыг хааж, барилгын ажил явагдах тул тухайн замаар зорчих хөдөлгөөнийг зохицуулж тогтсон нэг маршрутыг зохион байгуулах. Зам тавих гүйцэтгэгч компанийн ажлын гүйцэтгэлд төсөл хэрэгжүүлэгч компани хяналттай ажиллах	Ханбогд-Оюу Толгой-Жавхлант баг чиглэлийн хатуу хучилттай авто замын барилгын ажлын талбай

1.4.2. Шимт хөрсийг хамгаалах

Хүснэгт 5. 2017 онд хэрэгжүүлэх шимт хөрсийг хамгаалах хяналтын арга хэмжээнүүд

#	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилтийн баримт
1	Аливаа газар хөндөх үйл ажиллагааны өмнө шимт хөрсийг зохих гүнд хуулж, зөв зохистой хадгалах	Газар хөндөхийн өмнөх байгаль орчны шалгалтын тайлангууд; Батлагдсан газар хөндөх зөвшөөрлүүд;
2	Шимт хөрсийг хадгалах талбайг зөв тодорхойлох, овоолгыг зөв үүсгэхэд хяналт тавих (3 метрээс өндөргүй овоолох, 60 метр тутамд 8 метр өргөнтэй зам үлдээх)	Батлагдсан газар хөндөх зөвшөөрлүүд; Ургамлын багийн шалгалтын тайлангууд
3	Урт хугацааны шимт хөрсний овоолгын бүртгэл хөтлөх, хаягжуулах	Геомэдээллийн сан; Шимт хөрсний бүртгэлийн хуудас Овоолгын талбайд байрлуулсан хаягнууд/самбарууд
4	Шимт хөрсний овоолгыг салхины элэгдлээс хамгаалах буюу гадаргууг ургамалжуулах туршилтыг үргэлжлүүлэх	Биологийн нөхөн сэргээлтийн гүйцэтгэлийн тайлан
5	Шимт хөрсний овоолгуудад чанарын хяналт шинжилгээ хийх	Лабораторийн шинжилгээний хариунууд; Байгаль орчныг хамгаалах жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан
6	Шимт хөрсний ашиглалтыг хянах: - тухайн газраас хуулсан шимт хөрсийг тухайн газрын нөхөн сэргээлтэнд ашиглахыг чухалчлах; - урт хугацааны овоолгоос ашиглах тохиолдолд аль болох хуучин овоолгыг сонгох; - шимт хөрсийг Байгаль орчны хэлтсээс тогтоосон зузаантайгаар техникийн нөхөн сэргээлтийн талбайд тараах, хянах; - шаардлагатайгаас илүү хэмжээний шимт хөрсийг урт хугацааны овоолгоос тээвэрлэхгүй байхад хяналт тавих;	Шимт хөрсний бүртгэлийн хуудас; Техникийн нөхөн сэргээлтийн гүйцэтгэлийн тайлангууд

1.5. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 6. Агаарын чанарын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ
1	Уур амьсгалд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр - Хүлэмжийн хийг ялгаруулж буй эх үүсвэрүүдийн мэдээллийг бүртгэх, тооцоолох	Төсөл хэрэгжиж буй бүх байршилд
2	Уур амьсгалд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр - Шинээр тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл худалдаж авахдаа тухайн хэрэгслийн үр ашигтай байдал болон түлшний зарцуулалтыг харгалзан үзэх	Уурхайд ашиглагдаж байгаа нийт тээврийн хэрэгсэл, хүнд машин механизм
3	Уур амьсгалд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр - Тээврийн хэрэгслийн ашиглалтыг сайжруулах, оновчтой төлөвлөх, зогсож байх үед унтрааж байх	Төслийн талбайд
4	Уур амьсгалд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр - Эрчим хүчийг хэмнэж үр ашигтай зарцуулах	Төслийн талбайд
5	Уур амьсгалд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр - Хог хаягдлын хэмжээг бага байлгах, үүссэн хог хаягдлыг дахин боловсруулах, дахин ашиглах, 3R (Бууруулах, дахин ашиглах, дахин боловсруулах) зарчмыг хэрэгжүүлэх	Хог хаягдал боловруулах төв
6	Уур амьсгалд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр - Барилгын ажлын үед эвдэгдэх/хөндөгдөх газрын хэмжээг аль болох бага байлгах, барилгын ажил дууссаны дараа нөхөн сэргээх	Барилгажилтын ажил явагдаж буй хэсэгт
7	Замын тоосжилтыг бууруулах зорилгоор усалгааг өдөр бүр хийх	Төслийн талбайн дотоод зам, нисэх буудал хүртэлх зам зэрэг шаардлагатай бүх зам, усалгаа хийх боломжтой дулааны улиралд
8	Төслийн талбайн дотоод замаас үүсэх тоосжилтийг бууруулах - Замын засвар, арчилгаа хийх	Төслийн талбайн дотоод зам, бүтэн жилийн турш
9	Төслийн талбайн дотоод замаас үүсэх тоосжилтийг бууруулах - хурдны хязгаарыг дагаж мөрдүүлэх (Хурдны хязгаарын тэмдэг, тэмдэглээ байрлуулах, тээврийн хэрэгслүүдэд байрлуулсан GPS-ийн мэдээнд хяналт тавих)	Төслийн талбай; Бүтэн жилийн турш
10	Ил уурхайн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтийг бууруулах - Хүчтэй салхитай үед хөрс хуулах, ачиж буулгах үйл ажиллагааг зогсоох	Ил уурхайн талбай, бүтэн жилийн турш
11	Хаягдал хадгалах байгууламжын өндөрлөгөө, өргөтгөлийн барилгын ажлын үед тоосжилт үүсгэж болзошгүй хуурайшсан гадаргуу, түр замуудыг чийгшүүлж байх	Хаягдал хадгалах байгууламжийн өргөтгөлийн барилгын ажлын талбай
12	Баяжуулах үйлдвэрийн анхдагч бутлуур, хүдрийн агуулахаас тоосжилт бий болохоос сэргийлж Хөөсөн тоос дарах системийг үргэлжлүүлэн ажиллуулах	Анхдагч бутлуур хүдрийн агуулах
13	Дулааны төв станцын технологид тохирсон нүүрс хэрэглэх, засвар үйлчилгээг тухай бүр хийх, бохирдуулагчын ялгарлыг шүүж, стандарт хэмжээнд барих шүүлтүүр ашиглах	Дулааны төв станц
14	Шатаах зуухнаас агаарт түгээмэл бохирдуулагч хий ялгаруулж, орчны агаарыг бохирдуулахаас сэргийлж, шүүлтүүрийг тогтмол сольж байх, зууханд үзлэг шалгалт, засвар үйлчилгээг тогтмол хийж байх.	Хог хаягдал боловруулах төвийн шатаах зуух
15	Агаарт хаягдах бохирдуулагч хийн хэмжээг бууруулах - Тээврийн хэрэгсэл, хүнд машин механизм, техникийг үзлэгт хамруулах, тэдгээрээс ялгарах хорт утааг стандартын төвшинд байлгах, техникийн үзлэг, засвар үйлчилгээг тогтмол хийж байх	Уурхайд ашиглагдаж байгаа нийт тээврийн хэрэгсэл, хүнд машин механизм; Бүтэн жилийн турш
16	Түлшний нөөцлүүр сав болон аянга зайлуулагчийн бүрэн бүтэн байлыг өдөр бүр шалгах, ил гаргах, оч үрэгсэхийг хатуу хориглох	Шатахүүн түгээх станц болон түлшний агуулах
17	БУЦБ, ХХБТ-ийн лагийн талбай болон булшлах талбайгаас эвгүй үнэр ялгарахаас сэргийлж ахуйн бохир болон хоолны үлдэгдлийг зориулалтын битүү машинаар тээвэрлэх	Хог хаягдал боловсруулах төв, Бохир ус цэвэршүүлэх байгууламж

18	Техник хэрэгсэл, тээврийн хэрэгслүүдээс гарах дуу шуугианы төвшинг тухайн тээврийн хэрэгслийн үйлдвэрлэгчээс зааж өгсөн дээ чимээний техникийн үзүүлэлтээс хэтрүүлэхгүй байх засвар үйлчилгээг тогтмол хийх	Уурхайн талбай орчмын техник хэрэгсэл, тэсрэх бодисын үйлдвэр болон зам дагуух бүх байгууламжууд
19	Тэсэлгээний үйл ажиллагааг явуулахдаа агаарын дэлбэрэлт, чичиргээний талаарх үндэсний болон олон улсын станьтын дагуу өдрийн ыагаар буюу 13:30-15:30 хооронд гүйцэтгэх тохиромжтой	Ил уурхай болон уурхайн ажилчдын тосгон
20	Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөргөлт болон агааржуулалтын систем үйлдвэрлэгчээс худалдан авалт хийх, засвар үйлчилгээг тухай бүр хийх	Төслийн талбай дахь агааржуулалт, хөргөлтийн систем бүхий барилга байгууламжууд
21	Зам барилгын ажилд ашиглах тээврийн хэрэгсэл, техник технологид багтагдсан төлөвлөгөөний дагуу техникийн үзлэг, хяналт шалгалт, засвар үйлчилгээг тогтмол хийх. Түлш шатахууны чанар, техникийн үргүй ажиллагаанд хяналт тавих	Зам барилгын ажилд ажиллаж буй буй бүх тээврийн болон техник хэрэгсэл
22	Түр ашиглахаар зассан замаас өөр газраар тээвэрлэлт хийхгүй байх, хурдыг хязгаарласан таних тэмдэг байршуулах, хяналт тавих	Зам барилгын ажлын талбай, замууд
23	Зам барилгын ажлын үед олборлолт явуулах ордуудын талбайн усалгааг тогтмол хийх	Олборлолт явуулж буй чулуу, шороон орд
24	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд ногдох агаарын бохирдлын төлбөрийг Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд заасан хувь, хэмжээгээр журмын дагуу тогтмол төлөх	Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслээс ялгарах нүүрс хүчлийн хийн төлбөрийг тэдгээрийн ангиллаас хамааруулах төлөх
25	Хайрга чулуу бутлах үед үүсэх тоосжилтийг хамгийн үүсгэх технологи ашиглах, бетоны тоосыг цэвэрлэж байх	Зам барилгын ажлын талбай
26	Барилгын болон тээврийн хэрэгсэл, техник, машин механизмуудын үүсгэж буй дуу шуугиан 70 дБ-ээс ихгүй байхаар зохион байгуулалтын арга хэмжээ авах;	Зам барилгын ажлын талбай
27	Дуу шуугианы эх үүсвэрийг тусгаарлах юмуу шингээх зориулалтын зөөврийн байгууламжтай байх, барилгын ажлын нөлөөллийн бүсэд байгаа айл өрхүүдийн ойр үйл ажиллагаа явуулахдаа түүнийгээ угсарч хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Айл өрх, суурин газарын орчимд үйл ажиллагаа явуулах үед
28	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр ашиглаж үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхдээ мэргэжлийн албаар дүгнэлт гаргуулан сум, дүүргийн засаг даргаас зөвшөөрөл авах, Мэргэжлийн байгууллагаар хэмжилт хийлгэж дүгнэлт гаргуулах	Агаарын бохирдлын суурин эх үүсвэрүүд
29	Агаарын бохирдлын эх үүсвэр бүхий аж ахуйн нэгж, байгууллага, иргэн агаарын бохирдлын төлбөр төлөх	Агаарын бохирдлын эх үүсвэрүүд

2. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2.1. Биологийн олон янз байдал

Хүснэгт 7. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хамтран хэрэгжүүлэгч	Биелэлтийн шалгуур	Баримтлах хууль, журам, стандарт
Байгал, зэрлэг амьтанд ээлтэй ноолуур төсөл	Өмнөговь аймгийн Номгон, Баян-Овоо сум	Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг	2017 оны төлөвлөгөөний биелэлт	БОНХ-ийн сайдын А-117 тоот тушаал, Өмнөговь аймгийн ИТХ-ийн 55-р тогтоол
Хууль бус антай тэмцэх төсөл	Өмнөговь аймгийн Номгон, Баян-Овоо, Манлай, Ханбогд, Дорноговь аймгийн Хатанбулаг, Хөвсгөл сумдын нутаг дэвсгэр	Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг	2017 оны төлөвлөгөөний биелэлт	Төсөл хэрэгжих сумдын удирдлага, хамтран ажиллах газар, агентлагын дарга нартай хийх гэрээ, харилцан ойлголцлыг санамж бичиг

2.2. Байгаль хамгааллын нэмэлт арга хэмжээ

Хүснэгт 8. Байгаль хамгааллын нэмэлт арга хэмжээний төлөвлөгөө

№	Арга хэмжээний чиглэл	Арга хэмжээний төрөл	Арга хэмжээний цар, хэмжээ
1	Олон нийтийн экологийн боловсролыг дээшлүүлэх	“Ногоон” өдөрлөгүүдийг зохион байгуулж мэдлэг, ухамсарыг нэмэгдүүлэх. Үүнд: * Мод тарих үндэсний өдөр * Дэлхийн нүүдлийн шувуудыг хамгаалах өдөрлөг * Дэлхийн биологийн олон янз байдлын өдөрлөг * Дэлхийн цөлжилттэй тэмцэх өдөр * Дэлхийн хөрс хамгааллын өдөр	иргэдийн байгаль, экологийн талаарх Өмнөговь аймгийн хэмжээнд
2	Биологийн олон янз байдлын судалгаа, шинжилгээний ажлын үр дүнг олон нийтийн хүртээл болгох	Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр биологийн олон янз байдлын талаар мэдээлэл хүргэх, орон нутгийн сонинд мэдээ бэлдэж иргэдэд тараах	Улсын хэмжээнд, Ханбогд, Манлай, Баян Овоо
3	ГБДЦГ-ын захиргаанд дэмжлэг үзүүлэх	ГБДЦГ-ын захиргааны байгаль хамгаалагчдад тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх	ГБДЦГ-ын хил хязгаарын хэмжээнд

3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

3.1. Техникийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Хүснэгт 9. 2017 онд техникийн нөхөн сэргээлт гүйцэтгэх талбайнууд

Д/д	Талбайн нэр	Талбайн хэмжээ /га/	Газар хөндөх зөвшөөрлийн дугаар
1. Лицензийн талбайд		1.22	
1.1	Элсний карьер	1.22	Байхгүй
2. Лицензийн талбайн гадна		3.50	
2.1	BP-ML05 карьер /Манлайн замын засварын ажил/	0.98	Байхгүй
2.2	BP-KB01 карьер /Манлайн замын засварын ажил/	2.52	ГХЗ-110817
Нийт талбай		4.72	

3.2. Биологийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Хүснэгт 10. Биологийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө - 2017

Нөхөн сэргээх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Арга хэмжээний цар, хүрээний задаргаа	Ажлын хэмжээ, га	Хэрэгжүүлэх хугацаа, сараар	
<ul style="list-style-type: none"> • Үрлэгч ашиглан үрэлгээ хийх • БУУГ бойжуулсан 2-3 настай хотир, тэсэгийн тарьц суулгацыг тарих 	Гүний Хоолойн зам барилгын ажлын явцад хайрга, дүүргэгч материал авсан карьер, кемпүүд	BP-PL04	2.97	VIII-X	
		Гэр кемп Б	2.56	V-VI	
<ul style="list-style-type: none"> • БУУГ бойжуулсан 2-3 настай сөөг, сөөгөнцөрийн суулгацыг тарих 	Усны хайгуулын явцад өрөмдсөн цооногийн нөхөн сэргээлт	Өрмийн цооногууд – А5, А4, А3, В6, В5, В3, U1, U2; Манлай - В1, В2, В9-12	3.50	VIII-X	
		Уурхайн үйл ажиллагаанд ашигласан элсний орд	Халивын элсний орд	2.03	VIII-X
		Уурхайн талбай гадна талд шинээр техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай	2016-2017 онд техникийн нөхөн сэргээлт хийгдсэн талбайд	4.74	VIII-X
Нийт га			15.80		

3.2.1. Ногоон байгууламж байгуулах

Хүснэгт 11. Лицензийн талбайд ногоон байгууламж байгуулах 2017 оны төлөвлөгөө

Арга хэмжээний зорилт	Хамрах хүрээ	Ажлын хэмжээ, га	Арга, аргачлал	Хэрэгжүүлэх хугацаа, сар
Төв суурийн газрын тохижилтод зориулан ногоон байгууламж байгуулах	Уурхайн лицензийн талбайд	0.5	Ханбогд суман дахь БУУГ бойжуулсан 2-3 настай мод, сөөгний тарьц суулгацыг тарьж, арчлан ургуулах	IV/15 - V/10; X/01 - X/25;
	Хөрш зэргэлдээ орших сумдын төвд	1		IV/15 - V/10; X/01 - X/25;

4. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Ханбогд сумын Малчин өрх, Ханбогд сумын Засаг дарга болон ОТ ХХК-с 2004 онд Нүүлгэн шилжүүлэх тухай 10, 2011/2012 онд Нөхөн олговрын тухай 89 гэрээг тус тус байгуулсан. Уг гэрээгээр тус компаниас тухайн өрхөд хороо бууц барих, малжуулах, худаг гаргах, хүүхдийн дээд сургуулийн оюутны сургалтын төлбөр, дунд сургуулийн сурагчийн хичээлийн бэлтгэл, богино хугацааны сургалтад хамрагдах зардал, хагас цагийн ажлын байраар тодорхой хугацаанд хангах зэргийг компанийн зүгээс хэрэгжүүлэхээр тохирсон болно. Компани Гэрээгээр хүлээсэн үүргээ тухай бүр хэрэгжүүлсэн бөгөөд одоогийн байдлаар сургалттай холбоотой дэмжлэгийг үзүүлсээр байна.

5. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 12. Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
Соёлын өвийн зааварчилгаа	ОТ	Газар хөндөх ажилтан	-
Соёлын ялгаатай байдал/ орон нутгийн зааварчилгааны багц боловсруулах	ОТ	Багц	1
Түүх соёлын дурсгалт газруудад ажиглалт мониторинг хийх	ОТ орчим	Дурсгалт газар	19
Бор овоог хамгаалах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх	ОТ	Булаг	1
